Батлав. БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга

_________________________________ /Г.Энхмөнх/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
Айваору ХХК-ийн захирал _________________________________/Д.Бадралхүү/

# *ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ "ХҮРЭН-1" НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-017559/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5234522/

Хянасан:
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн ________________________________________________

Боловсруулсан:
Айваору ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн _________________________Л.Анхбаяр

2025 он

## 1. Төслийн танилцуулга

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших “Хүрэн-1” нэртэй (166.7 га) MV-017559 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлийн талбай нь “АЙВАОРУ” ХХК-ийн /РД: 5234522/ эзэмшилд байдаг бөгөөд баруун хойд талаараа “Их Монгол Жонш” ХХК-ийн “Алаг толгой-1” нэртэй MV-011702 тоот, хойд талаараа “Дорноговийн үйлс” ХХК-ийн “Хөх дэл” нэртэй MV-011931 тоот, зүүн талаараа “Хөхтөр” ХХК-ийн “Хөх дэл-1” нэртэй MV021094 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй тус тус хиллэнэ.




Тус орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км, Дорноговь аймгийн төвөөс баруун хойшоо 130 км-т дунджаар д.т.д 1000м өндөрлөгт оршдог. Ордын байрлах Айраг сумын хил хязгаарын хувьд хойд талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан, баруун болон баруун урд талаараа Иххэт, Алтанширээ сумтай, өмнө болон зүүн талаараа Сайхандулаан, Дундговь аймгийн Өндөршил сумдуудтай хиллэдэг.

АШИГЛАЛТЫН СИСТЕМ

Ордын 1 болон 4-р хүдрийн биет нь босоо 55-70 градусын уналтай, баруун урдаас зүүн хойш 50 градусаар сунасан, судал хэлбэрийн хүдрийн биет тул дотоод овоолго хийх технологийн болон орон зайн боломжгүй. Иймд тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын систем хэрэглэхээр төсөлд тусгав. Уг ашиглалтын системийг хэрэглэх үед 871 мян.м3 хөрсийг гадаад овоолгод хураах ба хөрсний гадаад овоолгын талбайн хэмжээ 7.8 га, хөрс тээврийн зай уурхайн ашиглалтын жилүүдэд дунджаар 0.75 км байна.

## ИЛ УУРХАЙН ЗАГВАРЧЛАЛ

Хүдрийн 4-р биет болон хүдрийн 1-р биет дээр тус тусдаа ил уурхай үүсэх бөгөөд ил уурхайн доголын өндөр хүдэр болон хөрсөнд уул геологийн нөхцөлөөс хамаарч ашиглалтын доголыг 2.5-5 м-н өндөр байхаар тооцсон. Чулуулгийн төрлөөс хамааран доголын хажуугийн өнцөг 60 градус байна. Ил уурхайн эцсийн хүрээнд доголыг тулгаж хаахад 4 доголыг нэгтгэж 10 м өндөртэй болгож хажуугийн өнцгийг 60 градус хүртэл налуулна. Аюулгүй тавцангийн өргөнийг 3 м-р сонгож авсан. Транщейн замын өргөн 10 м байна. Энэ нь 2 урсгалтай 25 тн даацтай автосамосвал явах замд хангалттай хүрэлцэнэ. Транщейн налуу 100%.

| Үзүүлэлт | Нэгж | Тоон үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Уурхай №1 /ХБ-4/ | Уурхай №2 /ХБ-1/ |
| Уурхайн амсрын дундаж урт | метр | 210 | 130 |
| Уурхайн амсрын дундаж өргөн | метр | 160 | 46 |
| Уурхайн гүн | Метр | 65 | 20 |
| Уурхайн ёроолын дундаж урт | метр | 70 | 10 |
| Уурхайн ёроолын дундаж өргөн | метр | 25 | 20 |
| Уурхайн хажуугийн өнцөг | градус | 39-42 | 47-50 |
| Доголын өндөр | метр | 10 | 10 |
| Аюулгүй бермийн өргөн | метр | 3 | 2 |
| Траншейн өргөн | метр | 10 | 10 |





Ил уурхайн загварчлал /4-р хүдрийн биет/



Ил уурхайн загварчлал /1-р хүдрийн биет/

## ИЛ УУРХАЙН УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Хүрэн-1 хайлуур жоншны ордыг ил уурхайгаар ашиглах ТЭЗҮ-ийн боловсруулахдаа олборлосон хүдрийг баяжуулан 65% агуулгатай бүхэллэг жонш гаргаж борлуулна. Мөн бага агуулгатай үлдэгдэл хүдрийг флотацийн баяжуулах үйлдвэрт борлуулахаар тооцсон. Ил уурхайгаас гарах хөрсийг гадаад овоолгод хураахаар төлөвлөсөн. Ашиглалтын уг хугацаанд үүсэх хөрсний эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр төсөлд тусган оруулсан. Уурхайн ашиглалтын үед нийт 871 мян.м3 хөрс хуулах бол хаягдал, бохирдол тооцсоноор нийт 138 мян.тн хүдэр олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 6.6 м3/тн байна. Уурхайн олборлолтын төлөвлөгөөг дараах хүснэгтээр үзүүлэв.

Энд 1 жил буюу 12 сар ажиллахаар төлөвлөсөн боловч 2025 оны тухайд 3-4 сар ажиллах хугацааны боломжтой байгаа тул энэ жилийн ажил төлөвлөсөн хэмжээний 30%-д хүрэх болов уу гэсэн таамаглалтай байна.

| Ашиглалтын жил | Ашиглалтын нөөц | | | | | Хөрс хуулалтын коэффициент | Ашиглалтын үеийн хаягдал, бохирдол | | | | | Үйлдвэрлэлийн нөөц | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүдэр | | Агуулга | Эрдэс | Хөрс | | Уулын цул | Бохирдлын хувь | Бохирдлын хэмжээ | Хаягдлын хувь | Хаягдлын хэмжээ | Хүдэр | | Агуулга | Овоолгод буух хөрс |
| нэгж | м³ | тн | % | тн | м³ | | м³ | % | тн | % | тн | м³ | тн | % | м³ |
| 1 | 24,893 | 64,722 | 36.98 | 23,931 | 452,949 | 7.00 | 477,842 | 9.3 | 6,019 | 4 | 2,589 | 26,212 | 68,152 | 33.71 | 451,537 |
| 2 | 25,557 | 66,447 | 41.48 | 27,561 | 418,191 | 6.29 | 443,748 | 9.3 | 6,180 | 4 | 2,658 | 26,911 | 69,969 | 37.81 | 416,741 |
| **НИЙТ** | **50,450** | **131,169** | **39.26** | **51,492** | **871,140** | **6.64** | **921,590** | **9.3** | **12,199** | **4** | **5,247** | **53,123** | **138,121** | **35.79** | **868,278** |

## УУРХАЙН ХҮЧИН ЧАДАЛ, УУЛЫН АЖЛЫН ГОРИМ

Уурхайн хүчин чадлыг захиалагчаас өгсөн техникийн даалгаварын дагуу жилд 65.5 мян.т жоншны хүдэр олборлоно. Уурхай нь жилд 340 хоног ажиллана. Хоногийн 2 ээлжээр

ажиллах бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Ажилчид 14 хоног уурхай дээр ажиллаж 14 хоног амрах горимоор ажиллана. Бүх нийтийн амралтаар уурхайн үйл ажиллагааг зогсоохгүй ажиллана. Бүх нийтийн амралтаар ээлж таарсан ажилчдад Хөдөлмөрийн тухай хуулиар цалин хөлсийг тооцож олгоно.

Ил уурхайн тоног төхөөрөмжүүд нь хуучин тоног төхөөрөмжүүд тул төслөөр техник ашиглалтыг дунджаар 70% байхаар тооцов. Тоног төхөөрөмжүүд нь жилд дунджаар 2209 мото-цаг ажиллана.

Уурхайн болон тоног төхөөрөмжийн ажиллах горимын үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

| Тодорхойлолт | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Хэмжээ |
|---|---|---|---|
| **Уурхайн ажиллах горим** | Календарь хоног | Хоног | 365 |
| | Давагдашгүй хүчин зүйл (сул зогсолт) | хон/жил | 15 |
| | Ажиллах хоног | хон/жил | 340 |
| | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг/ээлж | 12 |
| | Хоногт ажиллах ээлж | ээлж/хон | 2 |
| | Хоногт ажиллах цаг | цаг/хон | 12 |
| | **Төлөвлөгөөт цаг** | **цаг/жил** | **8160** |
| **Ээлжийн ажиллах горим** | Хоолонд орох хугацаа (60 мин/ээлж ) | цаг/жил | 680 |
| | Үзлэгийн хугацаа (15 мин/ээлж) | цаг/жил | 170 |
| | Түлш цэнэглэх хугацаа (10 мин/ээлж) | цаг/жил | 114 |
| | Байр сэлгэх хугацаа (20 мин/ээлж) | цаг/жил | 226 |
| | Бусад тооцоологдоогүй (20 мин/ээлж) | цаг/жил | 227 |
| | **Нийт** | **цаг/жил** | **1417** |
| | **Цаг ашиглалтын коэффициент** | **%** | **82%** |
| **Тоног төхөөрөмжийн ажиллах горим** | **Төлөвлөгөөт цаг** | **цаг/жил** | **8160** |
| | Төлөвлөгөөт засвар үйлчилгээ | цаг/жил | 632 |
| | Төлөвлөгдөөгүй засвар үйлчилгээ | цаг/жил | 1262 |
| | **Бүтээлтэй ажиллах цаг** | **цаг/жил** | **6266** |
| | **Техникийн бэлэн байдал** | **%** | **80** |
| | **Техник ашиглалт** | **%** | **70** |

Хөрсний овоолго

Ил уурхайн ашиглалтын хугацаанд 4-р хүдрийн биетийг ашиглах уурхайн баруун хойд талд уурхайгаас 35 м зайд хөрсний гадаад овоолго, 1-р хүдрийн биетийг ашиглах уурхайн баруун урд талд уурхайгаас 25 м зайд хөрсний гадаад овоолго үүснэ. Хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлэн, автосамосвалаар тээвэрлэж гадаад овоолгод хураах ба уг процессын үр дүнд хөрс 10-20%-иар сийрэгжинэ. Уг хөрсний овоолгын багтаамж нь сийрэгжсэн эзлэхүүнээр 1,041.6 мян.м3 байна. Хөрсний овоолгуудын хэмжээсийг дараах хүснэгтэд үзүүлэв.

| Ашиглалтын жил | Овоолгын хэмжээ, $м^3$ | Талбай, $м^2$ | Талбай, га | Өндөр | Өргөн, м | Урт, м |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | 541,844 | 39300 | 3.93 | 20 | 160 | 140 |
| **2** | 500,089 | 39300 | 3.93 | 30 | 80 | 50 |
| **Нийт** | 1,041,934 | 78,600 | 7.86 | 30 | 240 | 190 |

## ИЛ УУРХАЙН ТЕХНОЛОГИ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН СОНГОЛТ

Хүрэн-1 хайлуур жоншны ил уурхайд экскаватор-автосамосвалын хослол бүхий тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр олборлоно. Ашиглалтын системийн хүрээнд ухаж ачихад бэлтгэх, ухаж ачих, тээвэрлэх, овоолох, туслах ажил зэрэг технологийн үндсэн ажиллагаанууд (процесс) хийгдэнэ. Төслийн хүчин чадал жилд дунджаар 450,0 мян.м3 уулын цул үүнээс 64.7-66.4 мян.т хүдэр, хөрс хуулалт 418-450 мян.м3 байна.

Уулын ажилд шаардлагатай зарим тоног төхөөрөмжүүдийг түрээсээр ажиллуулна. Ил уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжийн сонголтыг дараах хүснэгтэд үзүүлэв.

| д/д | Тоног төхөөрөмж | Төрөл | Хүчин чадал | Тоо, ш |
|---|---|---|---|---|
| **Уурхайд одоо байгаа тоног төхөөрөмж** | | | | |
| **1** | Экскаватор | HYUNDAI R370LC | 2.1 м$^3$ | 1 |
| **2** | Экскаватор | Doosan DX300LC | 1.27 м$^3$ | 1 |
| **3** | Автосамосвал | Howo | 25 т | 6 |
| **4** | Утгуурт ачигч | Liugong ZL50CN | 3 м$^3$ | 1 |
| **5** | Утгуурт ачигч | Liugong LG550 | 1.7 м$^3$ | 1 |
| **Түрээсээр ашиглах тоног төхөөрөмж** | | | | |
| **1** | Бульдозер | Shantui SD23 | 162 кВт | 1 |
| **2** | Грейдер | PY-135 | 3.6 м | 1 |
| **3** | Түлш цэнэглэгч машин | Faw | 3 т | 1 |

## БАЯЖУУЛАХ СХЕМИЙН СОНГОЛТ, ТООЦОО

"Хүрэн-1" хайлуур жоншны ордын хүдрийг баяжуулах технологийн схемийг "Ханлаб" ХХК-ийн хагас үйлдвэрлэлийн технологийн туршилтын үр дүнгийн үзүүлэлт болон бусад ижил төстэй ордын технологийн судалгаа үндэслэл болгон дараах схемээр баяжуулна.



Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн нэгдсэн жагсаалт

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Төрөл | Тоо | Хүчин чадал | Суурь чадал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хацарт бутлуур | PEF500x750 | 1 | 35-68 тн/цаг | 55 |
| 2 | Чичиргээт шигшүүр | $SZZ_4$1400x3000 | 1 | 40-80 тн/цаг | 7.5 |
| 3 | -80+30мм-ийн ширхэглэлтэй хүдрийг өнгөөр ялгах төхөөрөмж | RS512CG | 1 | 30 тн/цаг | 5.5 |
| 4 | -30+10мм-ийн ширхэглэлтэй хүдрийг өнгөөр ялгах төхөөрөмж | Beltscan 1200CG | 2 | 4.5 тн/цаг | 5 |
| 5 | Конвейер | 500 | 1 | 50 тн/цаг | 7.5 |
| 6 | Конвейер | 500 | 6 | 30 тн/цаг | 11 |
| 7 | Конвейер | 500 | 4 | 30 тн/цаг | 7.5 |
| | **Нийт** | | **16** | | **99** |

## УУРХАЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

Хүрэн-1 хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл нь олборлолтын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай бүхий л барилга байгууламжийг байгуулсан байна. Төслийн талбай дээр дараах барилга байгууламж байна. Үүнд:

- Уурхайн ажилчдын амрах байр
- Инженер техникийн ажилтны байр
- Баяжуулах үйлдвэр
- Бутлуурын хэсэг
- Засварын газар
- Шатахуун түгээх станц
- Тэсрэх материалын агуулах
- Харуулын байр
- Дизель генераторын станц зэргийг байгуулан ашиглаж байна.

### Ажилчдын амрах байр

Уурхайн ажилчдын амрах байр нь уурхайн ажлын горим, төсөл эзэмшигч компанийн засаглалын хэлбэр, соёлоос хамааруулан төслийн менежментийн багийн бүтэц, бүрэлдэхүүн ямар байх, оффис-үйлчилгээний барилга байгууламжийн хэрэгцээний төсөөлөл, нийт ажиллагсдын тоо, бүтцийг тодорхойлсны үндсэн дээр орон сууц, соёл-амралт, эрүүл ахуй, ахуйн үйлчилгээний төрөл, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан төсөөлж, байгуулагдсан байна.



Аянганаас хамгаалах газардуулгатай

### Тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн агуулах

Уурхай нь ашиглалтын хугацаанд нийт 225 тн тэсрэх бодис хэрэглэнэ. Тэсрэх бодисын жилийн дундаж хэрэглээ 112.5 тн байна. ТБ-ын агуулах нь уурхайн тэсрэх бодисын хэрэглээг бүрэн хангана. ТБ-ыг ашиглах, хадгалах, түгээх, тээвэрлэх ажлыг ТБ–той харьцах норм дүрмийн дагуу явуулна. ТБ–ын агуулахыг аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн

дагуу осол авааргүй зайд байрлуулж харуул хамгаалалтаар хангасан.



Авто зогсоол

Уурхайд дээр байнга ажиллах тоног төхөөрөмж нь уурхайн ачигч машин, уурхайн тээврийн автосамосвал, тогтмол бус байх гадаад тээврийн автосамосвал, уурхайн бусад ажилд суудлын машин, бага оврын ачааны машин, усалгааны машин байна. Эдгээр машинуудад зориулж  машины түр зогсоол байгуулах бөгөөд улирлын ажил дуусч уурхай түр консервацид ороход сумын төв рүү нүүж тусгай дулаан гаражд байрлуулахаар төсөлд тусгав. Сумын төвд байрлах машин нь дугуйт ачигч, усалгааны машин байна.



Баяжуулах үйлдвэр

Хуурай аргаар жонш баяжуулах үйлдвэр нь хацарт бутлуур, шигшүүр, гар аргаар ялгах конвейер, жонш ялгах технологийн 3 шугамнаас бүрдэнэ.



## 2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

**Уул зүй -** Айраг сум нь геоморфлогийн хэв шинжийн хувьд Төв Азийн геоморфологийн их муж, Даланзадгад - Сайншанд, Баяндэлгэрийн дэд мужид хамаарагдана. Ерөнхийдөө нутгийн төв болон зүүн хэсгээр дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх гүвээт, тэгш давхаргат тал, ширгэдэг нуурын ёроолын ба хужир марзат хэв шинжтэй. Харин Сайн-Ус багийн зүүн хойд хэсгээр татмын нам дэнжийн хурдаст талтай. Нард багын . нутгаар алаг цоог тархсан цав толгод ширгэдэг нуурын ёроолын ба нуур пролювийн хосолсон хэв шинжтэй.

Тухайн районы уул толгод нь тэгшивтэр бөмбөгөр оройтой, налуу хажуутай, гуу жалгандаа үерийн усаар идэгдсэн, эгц эргэрхэг гуу, хуурай сайруудтай, толгод хоорондын битүү хотгоруудад хур бороотой үед түр зуурын жижиг нуур цөөрөм үүсдэг.

Гадаргуугийн үнэмлэхүй өндөр нь районы баруун, баруун хойд ба зүүн хойд хэсгээр байрлах уулсын 1394-1617м-ийн хооронд хэлбэлзэх ба уул толгодын орой, өндөрлөгүүд ихэвчлэн бие биетэйгээ зэрэгцэн оршдог. Нам дор газрынх 1200-1300м, харьцангуй өндөр нь 100-200м-ийн хооронд хэлбэлздэг байна.

**Ус зүй -** Төв азийн гадагш урсгалгүй ай савд багтах ба түр урсгал бүхий гол горхитой мужид ангилагддаг. Нэгж тайлбайд ноогдох голын нийлбэр урт 0,01 км/км$^2$, хаврын шар ус, зуны хур борооны усаар тэжээгддэг хэд хэдэн голтой. Улаан нуур, Зүүн улаан нуур, Дөрвөлжин нуур, Гашуун тойром гэх мэт зун хур борооны усаар тэжээгддэг хэд хэдэн нууруудтай. Голын тэжээлийг хувиар илэрхийлбэл газар доорх ус 20%, цасны ус 25%, хур борооны ус 55% байна. Метантай давсархаг ба шорвог, нүүрсхүчлийн хүйтэн рашааны мужид хамаарагддаг.

Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 4 худаг, 2 усан сан, 225 м$^3$/хоног хүчин чадалтай 1 насос станц, 20 м$^3$/хоног хүчин чадалтай 1 ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж бөгөөд цэвэр усны 2.8 км урт шугам хоолойгоор ус түгээдэг.

**Хөрс, түүний бүтэц бүрэлдэхүүн -** Хуурай хээрийн ба цөлжүү хээрийн хөрс зонхилсон бөгөөд зарим хэсгээрээ давсархаг, татмын ба сайрын хөрстэй. Хөрсөн бүрхэвчийн бүтцэд уугуул ба чийгт хээрийн хөрс зонхилсон. Нартын хад хавиар ил гарсан хад чулуу бүхий дутуу ба гүйцэд хөгжилтэй хөрстэй.

Нутгийн төв хэсгээр нунтаг карбонат зонхилсон. Нийт нутгаар бүхэлдээ хүчтэй хийсэх аюултай элсэн хөрс, нартын хад хэсгийн багахан газар хүчтэй элэгдсэн гадаргатай.

**Ургамал зүй -** Ургамал зүйн хувьд тал хээрийн ургамал голлох бөгөөд харгана, бударгана зэрэг бутлаг ургамал, таана, монгол өвс, хиаг, агь, хялгана, ерхөг, шарилж, дэрс, халгай, зэгс зэрэг нэг ба олон наст ургамал тус тус зонхилон ургана. Ботаник газарзүйн мужлалаар айраг сум нь Евро Азийн хээрийн их муж дагуур, Монголын хээрийн мужид хамаарагддаг. Говийн умард Монголын хэв шинж зонхилдог.

Байгалийн мужлалаар говийн бүсэд багтдаг болович нутгийн баруун хойт хэсэг нь хээр талын бүсэд хамаарна. Говь хээр хосолсон энэ нутагт таана, хөмүүл, хайлас, цагаан бургас, алтан харгана, лидэр, алтан үндэс, монгол буйлс, морин зээргэнэ, цайны бут, зээрийн ундаа, чихэр өвс, мангир зэрэг 120 гаруй нэр төрлийн эмийн болон эмийн бус ургамал ургадаг ба эмэнд ордог 10 гаруй төрлийн чулуу бий.

**Ан амьтан -** Амьтны аймгийн хувьд ургамлын бүрхэвч сайтай учир зэрлэг амьтны тархалт нилээд их байдаг. Амьтны төрөл зүйлээр баян бөгөөд тэдгээрээс цагаан зээр, сохор номин, алаг даага, харх, тарвага, зурам, туулай, чоно, үнэг, хярс, өмхий хүрэн, зараа, могой зэрэг олон төрлийн амьтад амьдардаг. Харин жигүүртэн шувуудаас тогоруу, бүргэд, элээ, ятуу,

бор шувууд, хэрээ зэрэг байдаг. Мөн зээр, туулай, тарвага, бозлог, үлийн цагаан оготно зэрэг өвсөн тэжээлтэн, могой хонин ба могой гүрвэл, мэлхий, царцаа, голио зэрэг нисдэг ба мөлхөгчид элбэгтэй.

Хавар намартаа хачиг, хувалз ихээхэн тархдаг нутаг юм. Харин жигүүртний аймаг олон төрөл зүйлтэй, тэдгээр нь тархалт ихтэй. Тус нутагт тас, бүргэд, хэрээ, элээ, харцага шонхор, сар зэрэг махчин, тагтаа, чогчого, бялзуухай мэтийн Монгол оронд байдаг бүхий л шувууд тохиолдоно.

**Цаг агаар -** Судалгааны бүс нутагт жилийн дөрвөн улирал бүхий эх газрын эрс тэс уур амьсгал зонхилдог бөгөөд агаарын чийгшил багатай хуурайвтар, хур тунадасны хуваарилалт бага, агаарын температурын улирал, сар, хоногийн хэлбэлзэл их байдаг.

Хамгийн хүйтэн сар нь 1-р сар бөгөөд сарын дундаж температур нь -18$^0$C, хамгийн халуун сар нь 7-р сар ба сарын дундаж температур нь +20,2$^0$C байдаг. Жилийн дундаж температур нь 3$^0$C. +30$^0$C ба түүнээс дээш температуртай өдрийн тоо дунджаар 30 байхад -30$^0$C ба түүнээс доош температуртай өдрийн тоо дунджаар 20 байна. Агаарын температур хоногийн дунджаар +10$^0$ ба түүнээс дээш байх өдрийн тоо 140 байгаа нь Монгол улсын нийт дундажтай харьцуулахад өндөр байгаа нь ажиглагдсан бөгөөд агаарын дундаж температур 1985 оны агаарын температураас 54% нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хур тунадасны жилийн дундаж хэмжээ 150 мм үүнээс дулаан улирлын хур тунадасны дундаж хэмжээ 200 мм бөгөөд 5мм ба түүнээс илүү хур тунасдастай өдөр 10 байна. Харин хүйтэн улирлын хур тунадасны дундаж хэмжээ 15 мм, цас орсон өдөр 20 байна. Нутгийн хэмжээнд тогтвортой цасан бүрхүүл үүсэх хугацаа нь 12 сарын 1-10 хооронд, цасан бүрхүүл үүсэх дундаж хамгийн их зузаан нь 7,5 см байх бөгөөд энэ үеэр тогтвортой цасан бүрхүүлийн хугацаа олон жилийн дунджаар 75 өдөр үргэлжилнэ.

Айраг суманд хамгийн ойр орших нарны цацрагын цаг уурын станц Сайншанд суманд байрладаг. Нарны нийлбэр цацрагын дундаж 1500 квт.цаг/м$^2$ буюу нэг жилд нар гийгүүлэх хугацаа 3100 цаг байдаг. Далайн төвшнөөс дээш 1500 м дэх агаарын жилийн дундаж даралт нь 846 гПа байна. Харин агаарын 1 дүгээр сарын дундаж даралт 848 гПа бол агаарын 7 дугаар сарын дундаж даралт 845 гПа ажээ.

Жилд дунджаар 15 м/с ба түүнээс хүчтэй салхитай өдөр 25, шороон шуургатай өдөр 20, цасан шуургатай өдөр 7, явган шуургатай өдөр 8 байна. Зураг төсөл, барилгын ажилд зориулсан салхины хурдын тооцооны үзүүлэлтээр газрын гадаргаас 10 м өндөрт салхины хурдны шахах хүч 45 кг/м$^2$ байна.

Жилийн агаарын харьцангуй чийгийн дундаж 40%, 125 өдөр харьцангуй чийгшил 30%-аас бага байна. Агаарын харьцангуй чийгшил I сард 65% , IV сард 40%, VII сард 58%, X сард 48%, агаарын харьцангуй чийг 30% ба түүнээс бага байх өдөр 10–20 байна. Нийт нутгаар жилийн дундаж ууршилт 10–20 см бол ууршицын хэмжээ 80 см буюу түүнээс их байна.

**Дэд бүтэц -** Орд орчимтой ойрхон төв суурин газар нь бол Айраг сумын төв байдаг. Энд эмнэлэг, сургууль, шуудан холбоо, дэлгүүр бусад үйлчилгээний газруудтай. Мөн Харилцаа холбооны хувьд Mobicom, Unitel, Skytel, G-mobile зэрэг бүх үүрэн холбооны операторуудын сүлжээ маш сайн хөгжсөн байдаг.

Төмөр замын өртөөний хувьд Хар-Айргийн өртөөтэй ойрхон орд байрлана. Жилийн аль ч улиралд ердийн шороон зам болон засмал замаар саадгүй зорчих боломжтой.

## 3. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгүүд болон Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны уг төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагууд дээр үндэслэн тодорхойлсон. Мөн 2012 оны 5 дугаар сард УИХ-аар хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамал хамгааллын тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Хог хаягдлын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай зэрэг хуулиуд түүнтэй холбогдох бусад хуулиудад орсон өөрчлөлтүүд ялангуяа аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах талаар хүлээх үүргүүдийг тусгасан болно.

Хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежементийн төлөвлөгөөнд 5 жилийн хугацаанд урьдчилсан байдлаар **191258.3** мян.төгрөг /үүнээс нөхөн сэргээлт, хаалт, хяналт мониторингийн зардалд **49029.1 мян.төг**/ зарцуулахаар тусгасан. “Айваору” ХХК нь нарийвчилсан үнэлгээ батлагдсанаас хойш олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд энэ жил анх олборлолт явуулах гэж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар уурхайн олборлолтын үед гарч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, нэгэнт бий болсон сөрөг үр дагаврыг бага гэлтгүй тухай бүр нь нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх бололцоотой юм.

БОМТ-г хэрэгжүүлснээр дараах зорилтууд хангагдана. Үүнд:

- Монгол улсын БОАЖЯ- наас тавьж буй байгаль орчныг нөхөн сэргээх болон сөрөг нөлөөллийг бууруулах талаар тавьж буй шаардлагыг аль болохоор хангасан байх;
- Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шат дамжлага бүрт технологийн журам зааврыг байгаль хамгаалах хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандарт шаардлагад нийцүүлэх;
- Байгаль орчны менежментийн талаар БОНБНҮ-ээр дэвшүүлсэн зорилго зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг биелүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар төслийн холбогдох ажилтнуудад зориулан товч, тодорхой зааварчилгаа өгөх;
- Байгаль орчны менежментийн арга хэмжээ, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон, удирдлагын шатлалын дараалал бий болгох;
- Төсөл хэрэгжүүлэгч буюу гэрээт гүйцэтгэгч бүр байгаль орчныг хамгаалахтай холбоотой үүрэг хариуцлагаа мэдсэн байх ба үүргээ биелүүлэхэд шаардлагатай ур чадвар, бэлтгэл сургалт, мэргэжилтэй байх;
- Байгаль орчинд гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг аль болохоор бууруулж, байгаль орчныг хамгаалж байгаль орчны тухайн төлөв байдлыг хэвийн хадгалах зорилтыг хангах үүднээс үүнд хамаарах тодорхой тогтолцоо, дэг журам, ажлын зааварчилгааг тодорхойлох;
- Тухайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг төлөвлөж

явуулахад лавлах баримт бичиг болох;

Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг менежментийн төлөвлөгөөний зорилтуудтай нийцүүлэн явуулахын тулд байгаль орчны параметрүүд тус бүрд сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөгөөт ажил, төслийн ойр орчмын байгалийг хамгаалах талаар гүйцэтгэх ажлуудыг уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан болно.

Иймд менежментийн төлөвлөгөө нь энэ төслийн салшгүй нэг хэсэг төдийгүй түүнийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл нь болж өгнө.

***Төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө***

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан байна. Иймд дээрх хуулийн шаардлагын дагуу, төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг төслийн хүчин чадлыг өргөтгөх, өөрчлөх бүрд нэмэлт хийж байх шаардлагатай. Мөн үүнээс гадна, БОМТ-ний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

## 4. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Шаардагдах хөрөнгө /мян.төг/ | | | | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хэмжих нэгж | Нэгжийн зардал | Тоо хэмжээ | Нийт зардал | | |
| **1. Агаарын чанар** | | | | | | | | | |
| 1 | Уурхайн барилга байгууламж, олборлолт | Уурхайн дотоод тээврийн замаас тоосжилт үүсэхээс сэргийлэн тоос дарагч бодис цацах | Уурхайн дотоод тээврийн зам | | 1000.0 | Жилд 1 удаа | 1000.0 | 2025 | Замын тэмдэг, техникийн ерөнхий шаардлага<br>MNS 4597:2003<br>Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ, техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008<br>Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003<br>Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003<br>Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 5-р зүйлийн 5 дахь заалт, 7-р зүйл |
| 2 | Тээвэрлэлт, хүнд даацын машин механизмын нөлөөгөөр тоосжилт үүсэх | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хурдны хязгаарлалтыг 40-50 км/цаг, уурхайн дотоод зам талбайд 20 км/цаг-аар мөрдүүлэн ажиллах, хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулах<br>(Замын тэмдэг тэмдэглэгээний компаниуд: Мастер роад ХХК - 99993911, Хөхмөнх Сервис ХХК 21-253575, Монгол сутай интернэшл 99168467, 88002257) | Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам | | 50.0 | 20ш | 1000.0 | 2025 | |
| 3 | Машин механизмаас гарах хорт хий (нүүрсхүчлийн хий, бензоприн, | Ашиглагдаж буй тээврийн хэрэгслээс ялгарах хорт хийг стандартын түвшинд байлгах, стандартаас давсан тохиолдолд агаарын бохирдлын төлбөрийн | Уурхайд ашиглах тээврийн хэрэгслүүд | | -- | -- | -- | 2025 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нүүрсустөрөгч) агаарын чанарт сөргөөр нөлөөлөх | тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн төлбөрийг төлөх | | | | | | | |
| **2. Гадаргын ба газрын доорх усны нөөц** | | | | | | | | | |
| 4 | Усны нөөц багасах, бохирдох | Усны эх үүсвэрийг тоолуурржуулах, | Усны эх үүсвэр | | 250.0 | 1 | 250.0 | 2025 | Усны тухай хуулийн 28-р зүйл<br>Эрүүл ахуйн тухай хууль 4-р зүйл,<br>Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ<br>MNS0900:2018<br>Усны тухай хууль 30-р зүйл 6 заалт |
| 5 | | Уурхайн орчимд орших булаг шанд, гол горхины эх ундрагыг хамгаалах, хашаа хайс хийх / Хамгаалалтын бүсийг хийхдээ мал ундаалах эх үүсвэрийг гаргаж өгөх<br>/эрүүл ахуйн бүс энгийн 200 м, онцгой бүс 50 м/ | | | 1000.0 | 1 | 1000.0 | 2025 | |
| **3. Хөрсөн бүрхэвч** | | | | | | | | | |
| 7 | Уурхайн үйл ажиллагааны явцад хөрсний элэгдэл эвдрэл нэмэгдэх, | Уурхайн олборлолтоос үүдэн ойролцоох орчин доройтохоос сэргийлж төслийн талбайг хашиж хамгаалах, суваг шуудуу татах | Төслийн талбай | | -- | -- | -- | 2025 | Газрын хэвлийн тухай хууль 32-р зүйлийн 8 дахь заалт |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | доройтох, талхлагдах | Төслийн объектууд хоорондын явган хүний замыг засаж сайжруулах | Зам талбай | | Олборлолтоос гарах хайрга чулууг ашиглах | | | 2025 | Байгаль орчныг хамгаалах тухай хууль 25-р зүйлийн 1.2 дахь заалт |
| 9 | | Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хязгаарлах, тогтсон маршрутын дагуу явуулах үүнд ИТА-ын зүгээс хяналт тавьж ажиллах | Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам | | -- | -- | -- | 2025 | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль 7-р зүйлийн 2.5 дахь заалт |
| 10 | Уурхайн үйл ажиллагааны улмаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч доройтох, эвдрэлд өртөх | Уурхайн олборлолт, хөрсний гадаад овоолго, барилга байгууламжид өртөх талбайн үржил шимт хөрсийг зонхилох салхины чиглэлийн дагуу өндөр нь 5 м-ээс илүүгүй овоолж, өнгөн хэсгийг ургамалжуулах | Төслийн талбай | | -- | -- | -- | 2025 | Газар шорооны ажлын үед үржил, шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 |
| 11 | Хог хаягдал болон техникийн шатах, тослох материалаар хөрсөн бүрхэвч бохирдох | Машин техникийн засвар үйлчилгээг ТЭЗҮ-д заасан цэгт байгуулах, засвар хийгдэх талбай болон авто зогсоолыг хатуу хучилттай болгох<br>Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг мөрдөн ажиллах, нефт нефтийн бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд саармагжуулах | Засварын газар, авто зогсоол | | -- | -- | -- | 2025 | Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ<br>MNS 5850:2008 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгслийг байршуулах, бүрэн бүтэн байдлыг хянах | | | | | | | |
| 12 | | Хог хаягдлын цэгийг төвлөрсөн нэг цэгт байгуулж, Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу сар тутамд зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаях | Төслийн талбай | | 100.0 | Сар бүр | 300.0 | 2025 | Хог хаягдлын тухай хуулийн 10-р зүйлийн 2.3 дахь заалт, 10-р зүйлийн 2.7 дахь заалт, 17-р зүйлийн 4.1 дахь заалт,<br>Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль 7-р зүйлийн 2.1 дахь заалт |
| **4. Газрын хэвлий** | | | | | | | | | |
| 13 | Уурхай, овоолго болон уурхайн үйл ажиллагаанаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох | Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглах | Төслийн хүрээнд | | -- | -- | -- | 2025 | Газрын хэвлийн тухай хууль 31-р зүйлийн 1 дэх заалт |
